



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРТЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/116

Есөнбулаг

“Улсын хил хамгаалалтад туслах хүчний
орон тооны бус зөвлөл”-ийн нэгдсэн
зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол улсын хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар баталсан “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”-ын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Улсын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөл”-ийн нэгдсэн зөвлөгөөнийг 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулахыг зөвлөлийн орлогч, Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн захирагч (хурандаа Э.Майдар)-д үүрэг болгосугай.


2.Зөвлөгөөнөөр зөвлөлийн 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан 2024 онд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон холбогдох бусад асуудлыг хэлэлцэхийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д даалгасугай.

3.Зөвлөгөөнд оролцох бүрэлдэхүүний нэрсийг нэгдүгээр хавсралтаар, зөвлөгөөний хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар, бэлтгэл ажлын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар, зөвлөгөөнд зарцуулагдах зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

4.Зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах 1,842,000 (нэг сая найман зуун дөчин хоёр мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



تہذیب - سائنس و فنون
 وزارت تعلیم و تربیت

مکتبہ ملی

مکتبہ ملی

۹۴ ۵۰۰ ۱۰۰ ۲۵۰

«بیمار میں زچہ کی تشخیص کو طبی و
 عام معائنہ و علاج کے لئے»
 کے لئے نصاب و معائنہ

یہ کتاب بیمار میں زچہ کی تشخیص، اعضاء اور نصاب کی کتاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے
 ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے
 «بیمار میں زچہ کی تشخیص کو طبی و عام معائنہ کے لئے»
 کے لئے نصاب و معائنہ:

۱ «بیمار میں زچہ کی تشخیص کو طبی و عام معائنہ کے لئے» کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے
 ۱۲۰۰۰۰ تک کے
 کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے

۲ کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے
 کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے
 کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے

۳ کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے
 کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے
 کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے

۴ کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے
 کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے
 کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے

۵ کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے
 کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے
 کے لئے نصاب و معائنہ کے لئے ۱۲۰۰۰۰ سے ۱۲۰۰۰۰ تک کے



بیمار میں زچہ کی تشخیص کو طبی و عام معائنہ کے لئے

8002212472

Аймгийн Засаг даргын 2024 оны 02
дугаар сарын 02-ны өдрийн 4116 дугаар
захирамжийн хавсралт


**"УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ"-ИЙН НӨГДСЭН
ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ**

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг дарга
Орлогч дарга: Хилийн цэргийн 0214, 0166 дугаар ангийн захирагч
Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)
Аймгийн Засаг даргын орлогч
Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
Аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч
Аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор
Аймгийн Цагдаагийн газрын дарга
Аймгийн Онцгой байдлын газрын дарга
Тагнуулын ерөнхий газрын аймаг дахь хэлтсийн дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Мал эмнэлгийн газрын дарга
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
Говь-Алтай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга
"Мэдээлэл холбоо сүлжээ" ТӨХК-ийн аймгийн салбарын дарга
Гаалийн хорооны дарга
Хилийн боомтын захиргааны боомт хариуцсан төлөөлөгч

Говийн их дархан цаазат газрын "А" хэсгийн
хамгаалалтын захиргааны дарга

Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн
хамгаалалтын захиргааны дарга

Говь-Алтай аймаг дахь Хүний эрхийн үндэсний
комиссын референт



Хилийн сумдын хил хамгаалалтад туслах хүчний
салбар зөвлөлийн дарга нарын жагсаалт

Алтай сумын Засаг дарга

Бугат сумын Засаг дарга

Цогт сумын Засаг дарга

Тонхил сумын Засаг дарга

Эрдэнэ сумын Засаг дарга

---oOo---

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 08-ны өдрийн 0042 дугаар
захирамжийн хавсралт

**"УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ"-ИЙН НЭГДСЭН
ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР**

2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр

- | | |
|-------------|--|
| 13.50-14.00 | Зөвлөгөөнд оролцох бүрэлдэхүүнийг хүлээн авах, бүртгэх-
Х.Лхагважав, Ц.Ганчимэг (Засаг даргын тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн) |
| 14.00-14.05 | Зөвлөгөөний хөтөлбөр, засаг даргын захирамжийг
танилцуулах- Ш.Эрдэнэбат (Зөвлөлийн нарийн бичгийн
дарга, Засаг даргын Тамгын газрын дарга) |
| 14.05-14.10 | Зөвлөгөөнийг нээх- О.Амгаланбаатар (Зөвлөлийн дарга,
аймгийн Засаг дарга) |
| 14.10-14.20 | Хилийн цагийн байдлын талаар товч дүгнэлтийг
танилцуулах- О.Лхагвасүрэн (ТЕГ-ын Говь-Алтай аймаг
дахь хэлтсийн дарга, хошууч) |
| 14.20-14.35 | ХХТХЗ, ХХТХСЗ-өөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний
тайлан танилцуулах- Ш.Эрдэнэбат (Зөвлөлийн нарийн
бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга) |
| 14.35-14.55 | Есөнбулаг сумд хил хамгаалалтын зориулалттай газар
олгох бодомж, Улсын Их Хурлын 2022 оны "Монгол Улсын
хилийн зурвас газрыг тогтоож, улсын хэрэгцээнд авах
тухай" 81 дүгээр тогтоолыг танилцуулах- Д.Алтанзагас
(Газрын харилцаа барилга, хот, байгуулалтын газрын дарга) |
| 14.55-15.15 | Шинэ сэргэлтийн бодлого (боомтын сэргэлт) хилийн
"Бургастай", "Наран сэвстэй" боомтын дахин төлөвлөлт,
2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар-
Д.Цэрэвсамбуу (Хилийн боомтын зөвлөлийн төлөөлөгч) |
| 15.15-15.35 | Завсарлага (Цайны цаг) |
| 15.35-15.50 | Улсын хил хамгаалалтын эрх зүйн орчин, 2023 оны үр дүн,
2024 онд баримтлах бодлого, ХХТХОТБЗ-өөс авч
хэрэгжүүлэх арга хэмжээний талаар- Э.Майдар (Зөвлөлийн
орлогч дарга, хурандаа) |
| 15.50-16.05 | Улсын хилээр 2023 онд нэвтрүүлсэн бараа, тээврийн
хэрэгслийн гаалийн хяналт, бүрдүүлэлт, татварын үр
дүнгийн талаар- Д.Эрдэнэсүх (Гаалийн хорооны дарга) |

- 16.05-16.15 Хилийн цэргийн 0166 дугаар ангийн танилцуулга, 2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар- Л.Алтангэрэл (Зөвлөлийн орлогч дарга, Хилийн цэргийн 0166 дугаар ангийн захирагч, дэд хурандаа)
- 16.15-16.25 Улсын хилээр 2023 онд гарсан ХОД-ийн зөрчлийн шийдвэрлэлтийн талаар танилцуулах- Н.Цогтбаяр (аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх)
- 16.25-16.35 Хил орчмын нутаг дэвсгэрт гарч буй гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар- Н.Мэндбаяр (Цагдаагийн газрын дарга, хурандаа)
- 16.35-16.50 Хилийн цэрэгт 2022, 2023 онд алба хаасан иргэд, 2024 оны I ээлжээр алба хаах иргэдийн судалгаа- Д.Төмөрбаатар (Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа)
- 16.50-17.05 Улсын хилийн зурваст нэн ховор амьтдыг хамгаалах, хууль бус ан агнуур, байгалийн дагалт баялаг ашиглахаас урьдчилан сэргийлэх (Говийн их дархан цаазат газрын "А", "Б" хэсгийн дарга нар)
- 17.05-17.55 Хил орчмын сумдын Засаг дарга нар 2024 онд хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зардлын талаар танилцуулах- Х.Баатарзориг (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Л.Хаш-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
17.15 С.Эрдэнэжаргал (Алтай сумын засаг дарга)
17.20 Ч.Дашням (Бугат сумын засаг дарга)
17.25 М.Насанбат (Тонхил сумын засаг дарга)
17.30 Л.Насанбуян (Цогт сумын засаг дарга)
17.35 Б.Давааням (Эрдэнэ сумын засаг дарга)
- 17.55-18.15 Хил хамгаалах туслах хүчний орон тооны бус зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, албажуулах (ХХТХЗ-ийн гишүүд)
- 18.15-18.30 Зөвлөгөөнийг хаах- О.Амгаланбаатар (Зөвлөлийн дарга, аймгийн Засаг дарга)
- 18.30-19.00 Оройн зоог (Минж ресторан)- Ч.Хандмаа (Хууль зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч), О.Ажбаатар (Санхүүгийн тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч)
- 19.00-19.20 Урлагийн тоглолт (Минж ресторан) Г.Сүхбаатар Соён гэгээрүүлэх албаны ахлах офицер

19.20-20.00

Хил хамгаалалтад амжилт үзүүлсэн ХХТХЗ, ХХТХСЗ, ХХТХГ-ийг шагнаж урамшуулах, үнэмлэх гардуулах-
О.Амгаланбаатар (Зөвлөлийн дарга, аймгийн Засаг дарга),

Э.Майдар (Зөвлөлийн орлогч дарга, хурандаа)

Л.Алтангэрэл (Зөвлөлийн орлогч дарга, дэд хурандаа)

Ш.Эрдэнэбат (Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга)

-oOo-

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар
сарын 02-ны өдрийн 4116 дугаар
захирамжийн 3 хавсралт

"УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ"-ИЙН НЭГДСЭН
ЗӨВЛӨГӨӨНИЙ БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	ХХТХОТБЗ-ийн нэгдсэн зөвлөгөөний хөтөлбөр, үйл ажиллагааны дарааллыг боловсруулах	I/20	Ч.Хандмаа
2	Зочид, төлөөлөгчдийн уулзалт, зөвлөгөөний зардлыг шийдвэрлэх	I/20-25	Ш.Эрдэнэбат Х.Баатарзориг
3	ХХТХОТБЗ-ийн гишүүдэд нэгдсэн зөвлөгөөнд оролцох албан тоот хүргүүлэх	I/15-20	Ч.Хандмаа
4	Аймгийн засаг даргын хэлэх үгийг бэлтгэх	I/18-20	Ч.Хандмаа
5	ХХТХОТБЗ, ХХТХСЗ-тэй 2023 онд хамтран ажилласан дүн, 2024 онд хийх ажлыг хэлэлцэх бэлтгэл ажлыг хангах	I/20-25	х/а Э.Майдар Ш.Эрдэнэбат, д/х Л.Алтангэрэл
6	Зөвлөгөөн зохион байгуулах байр танхимыг бэлтгэх	I/30-II/01	Ч.Хандмаа
7	Аймгийн засаг даргын тушаалаар шагнуулах иргэдэд дурсгалын зүйл хадгалуулах судалгааг гаргах	I/25-II/01	х/а Э.Майдар Ш.Эрдэнэбат Ч.Хандмаа

-oOo-

Аймгийн Засаг даргын 2024
оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
011/2024 дугаар захирамжийн 11 хэсэрт

**"УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ"-ИЙН НЭГДСЭН
ЗӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАГДАХ ШААРДЛАГАТАЙ
ЗҮЙЛСИЙН ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Оройн хоол, үдийн цайны зардал	Ширхэг	40	-	1,800,000
2	Бичиг хэргийн зардал	Ширхэг	34	-	42,000
Нийт					1,842,000

-oOo-